



МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗАРТ

**МОНГОЛ УЛСЫН  
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА  
ХОЛБООНЫ САЙД**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160  
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,  
Цахим шуудан: info@mddc.gov.mn  
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2022.10.26 № 01/1858

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Мэдээлэл ирүүлэх тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолоор баталсан “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдлийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.2-т заасны дагуу өөрийн цахим хуудас болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд нийтэлнэ.” гэж заасан.

Тус яамнаас 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр мэдээлэл хариуцагч нарт Төрийн нэгдсэн портал сайт ([www.opendata.gov.mn](http://www.opendata.gov.mn))-д нээлттэй өгөгдлөө хэрхэн байршуулах талаар цахим сургалт, мөн нээлттэй өгөгдөл хариуцсан албан хаагч нарт 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр “Нээлттэй өгөгдлийн үнэ цэн” хэлэлцүүлгийг зохион байгуулж, мэдээлэл хүргэсэн.

Иймд Засгийн газрын 232 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-д хамаарах мэдээллээ 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн дотор өөрийн цахим хуудас болон Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд нийтлэх, шинэчлэх ажлыг зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана уу.



Н.УЧРАЛ

995778